

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар: 07

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилж, улсын
төсөвт төвлөрүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар тогтоол, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02/7613 дугаар албан бичиг, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 312 дугаар тогтоолоор улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоосонтой холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс төрийн өмчийн хувьцаанд ногдох 565,862,500 (таван зуун жаран таван сая найман зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөгийн ногдол ашиг хуваарилж, улсын төсөвт төвлөрүүлсүгэй.

2. Ногдол ашгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн 100900000702 тоот дансанд 2025 оны 4 дүгээр улиралд багтаан төвлөрүүлж, гүйцэтгэлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигч (Сангийн сайд)-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Тавинжил)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ц.Дашдондог)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ